

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖИЛД ОЛОН УЛСЫН БИЗНЕС ИНКУБАЦЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ТУРШЛАГААС

М. Төмөрбат*

Жижиг бизнесийн тухай

Түүхэнд бичигдсэнээс жижиг бизнес (ЖБ) нь МЭ 4000 жилийн өмнө оршин байсныг харж болно. Баячууд мөнгө хүүлэх үйл ажиллагаагаар л жижиг бизнес тодорхойлогдож байсан¹ бол тэр цаг үеэс хойш үйлдвэрлэгчид нь шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох гэж маш их цаг хугацаа, хүч зарсны үр дүнд жижиг бизнесийн шинэ онцлог чанарууд бий болж, хэлбэр нь ч илүү өргөн хүрээг хамрах болсон. Вавилон хаан нь хэрэглэгчид болон үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалсан, мөн луйвардлагын эсрэг 300 заалт бүхий хуулийг гаргасан. “Хэрэв барилгачин нь эздийн эрэлт хэрэгцээнд таарсан, чанартай байшин бариагүй, хэрэв байшин нурснаас болж хүний амь эрсдсэн бол барилгачныг цаазаар авна”² гэх мэт заалтууд орсон. 19-р зууны үеэс жижиг бизнест илт өсөлт бий болж олон жижиг аж ахуй эрхлэгчид, үйлдвэр, уурхай байгуулагдаж тэдний хэрэгцээнд тохирсон бизнесийн орчин, эрх зүйн таатай нөхцөл байдлыг бүрдүүлэх шаардлагатай болсон.

Жижиг бизнес нь эдийн засгийн дайвар салбар биш юм. Гэвч орчин үеийн хөгжлийн хурдацтай, өөрчлөлтийн нөхцөлд түүний гүйцэтгэх үүрэг нь улам нэмэгдэж байгаас дэлхий дахинаа ЖБ-ийг судлан улс орон бүр өөр өөрийн онцлогоос хамааруулан өөр өөрөөр тодорхойлсон байна.

Жижиг бизнесийн тодорхойлолт

АНУ	Үйлдвэрлэлийн гарц нь 3 сая доллараас дээш, 100-аас дээш ажилчинтай.
Европын холбооны улсууд	Жилийн цэвэр эргэлт 380 сая илүү, 500-аас доош тооны ажилтантай, хөрөнгийн 1/3 нь өөрийн үйлдвэрт эсвэл банкны мэдээлэлд байх.
Япон	Жилийн эргэлт нь 1 миллиард иен, 300-аас доош ажилтантай, 10-100 сая нь үндсэн хөрөнгөтэй
Сингапур	300.000 доллараас бага үндсэн хөрөнгөтэй, 100-аас доош ажилтантай

* МУИС, ОУХС-ийн багш, магистр

¹ Николас К. Сирополис, Управление малым бизнесом, Академия народного хозяйства при правительстве Российской Федерации, Москва, х – 1

² Николас К. Сирополис, Управление малым бизнесом, Академия народного хозяйства при правительстве Российской Федерации, Москва, х – 20

Тайлбар: ЖБ- Жижиг бизнес, БИ- Бизнес инкубатор

Эдгээр тодорхойлолт шалгууруудаас харахад улс орон бүр аж үйлдвэр, бизнесийн байгууллагын хөгжил, хүн амын өсөлтөөсөө хамаарч өөр өөрийнхөөрөө жижиг бизнесийг тодорхойлж байна. Жижиг бизнес гэдэг нь бусад байгууллагаас шууд хамааралгүй бие даан ажиллаж, орчиндоо харьцангуй бага нөлөө үзүүлдэг, хэн нэгэн болон хэсэг бүлэг хүний бүрэн мэдлийн бизнесийг хэлнэ.³

Бизнес инкубатор, түүний чиглэл ач холбогдол

Дэлхийн ихэнх орнуудын эдийн засгийн бүтцэд жижиг дунд үйлдвэрлэл, бизнес давамгайлах хандлагатай байна. АНУ-д ажлын байрны 60 хувь, ҮНБ-ний 40 хувь нь ЖДҮ-т ногдож, инновацийн 55 хувь нь энэ хүрээнд хийгдэж байна. Канадад 2.6 сая орчим ЖДҮ үйл ажиллагаа явуулж байгаагаас 500-аас доош ажилчидтай үйлдвэрүүдэд ажил эрхлэлтийн 60 гаруй хувь ноогддог бол Италид энэ үзүүлэлт 73%-тай байна. Өнөө үед ЖБ-ийн үйл ажиллагааг дэмжих, түүнд таатай орчинг бүрдүүлэх зорилготой ажилладаг бизнес инкубаторын үйл ажиллагаа нь хурдацтай хөгжиж, түүний үйлчилгээнд ЖДҮ-үүд ихэвчлэн 2-3 жил бойждог бөгөөд хамрагдагсдын 30% голдуу жил бүр төгсч байна. Америкийн салбарын дундаж нь төгсөгчдийн 87%, Европт 84% нь бизнесээ амжилттай үргэлжлүүлдэг. Иймээс энэ хүрээнд бизнес инкубаторын үйл ажиллагааны талаар дэлгэрүүлэн авч үзье.

Бизнес инкубатор (БИ)

БИ –ийг олон янзаар тодорхойлсон байдаг. “Бизнес инкубатор нь ЖБ эрхлэгчид болон компаниудыг нөөц болон үйлчилгээгээр хангаж, тэдний амжилт болон өсөлтийг хурдасгах зорилготой эдийн засгийн хөгжлийн хэрэгсэл юм. Гол зорилго нь хамтрагч фирмүүдээ үйл ажиллагаа нь бие даасан, санхүүгийн чадавхитай фирмүүдийг бэлтгэн гаргах явдал байдаг” гэж тодорхойлсон байдаг.

Бизнес инкубаторын зорилго

Мэдээллийн технологийн шинэ санаа, санаачилгыг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болгон хувиргах, шинэ технологид суурилсан бизнесийг хөгжүүлэхээр шинээр байгуулагдаж буй залуу компаниуд болон бизнес эхлэн эрхлэгчдэд урамшууллын таатай орчинг бүрдүүлэн ололт, амжилт болон үйл ажиллагааны хувьд тогтворжсон дотоод гадаадын зах зээлд өрсөлдөх чадвартай компани болгоход оршидог.

Бизнес инкубаторын ангилал

БИ нь нөөцийн сангаасаа хамааран БИ нь үндсэн 2 төрөлд хуваагддаг.

1. Ашгийн бус инкубатор
2. Ашгийн төлөөх инкубатор

Ашгийн бус бизнес инкубатор

Энэ төрлийн инкубатор нь их сургууль, судалгааны төвүүд, орон нутгийн болон төв засаг захиргааны байгууллагаас үүсэлтэй байдаг бөгөөд төв болон орон нутгийн засаг захиргаанаас гол төлөв санхүүждэг байна.⁴

³ Д.Д Речман, М.Х Мексон, “Орчин үеийн бизнес” Дэвтэр -1,2,4 УБ, 1997, х - 24


⁴ J. Bischoff. Regional perspectives on Promoting Business Technology Incubation system. 2002, Ulaanbaatar

Ашгийн төлөөх бизнес инкубатор

Энэ төрлийн инкубаторын олонх нь цэвэр бизнесийн инкубатор, технологийн фирм, эрсдэлийн капиталын фирм, зөвлөгөө өгөх үйлчилгээ эрхэлдэг фирм болон үйлдвэрлэлийн төслийн нэгжийн хэлбэртэй байдаг.

Бизнес эрхлэгч (гол төлөв залуу)-ийн сайтар бодож боловсруулсан үр ашигтай бизнесийн санааг хувь хүн, компаний зүгээс санхүүжүүлэх хэлбэр бөгөөд аз туршилт үлэмж өндөр тул ашиг олох боломж бага байдаг. Тиймээс БИ нь бизнесийн сайн санааг үүсэхээс эхлээд үйл ажиллагааг жигдрэх хүртэл бүхий л явцад хамтран ажиллаж, хяналт тавьдаг.

Жижиг бизнесийн инкубаторт бойжуулах үйл явц⁵



Зураг 1. Бизнес эрхлэгчид, инкубаторын харилцаа холбоо

БИ - Бизнес инкубатор

ТБИ - Технологи бизнес инкубатор

РР - Судалгааны парк

ИС - Инкубатор төв

ТИ - Технологи инкубатор

ТР - Технологийн парк

Бизнес эрхлэгчдийн инкубатортай холбогдох холбоог дээрх зурагт харуулсан. Эндээс харахад бизнесийнхээ шинэ санааг олоод, аж ахуй эрхлэх хүсэлтэй байгаа хүмүүст хамгийн ойр байдаг зөвлөгч нь бизнес инкубатор байдаг. Дэлхийн томоохон улсуудад бизнес инкубатор нь технологийн паркийнхаа дотор нь оршиж бусад технологийн болон технологи бизнесийн инкубаторуудтайгаа хамтран уялдаа холбоотой ажилладаг байна.

⁵ United States National Business Incubation Association Report 2006.03


Олон улсын бизнес инкубацийн хөгжлийн бодлого зохицуулалт

Дэлхий нийтэд хурдацтай хөгжиж байгаа технологи, бизнес инкубаторын практик туршлагыг судлан тэдний тэргүүн туршлагыг нь өөрийн оронд нэвтрүүлж дотоодын инкубаторуудын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, тэдний хөгжих таатай орчныг бүрдүүлэх шаардлага бидэнд байгаа, тиймээс судалгааны хүрээнд инкубаторын хөгжлийн түвшин нь хэдийнээ өндөр шатанд хүрсэн АНУ, БНХАУ, Солонгос, мөн түүнчлэн сүүлийн жилүүдэд энэ салбар нь шинээр үүсч, хурдацтай хөгжиж байгаа Непал зэрэг улсуудын ЖБ-ийг дэмжих БИ-ын бодлого зохицуулалтын орчны талаар авч үзлээ.

Бизнес инкубаторын бодлого зохицуулалтын орчин

Инкубаторын орчинг авч үзэхдээ түүний үйл ажиллагаанд нөлөөлж, хүрээлэн оршдог субъектүүдийг авч үзэх шаардлагатай байдаг. Үүнд: засгийн газар, засгийн хэрэгжүүлэгч агентлагууд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад сургалт, судалгааны төвүүд, их сургууль зэрэг субъектүүд орно.

Харин бизнес инкубаторын эрх зүйн орчинд засгийн газрын бодлого зохицуулалт, ЖДҮ, технологи дамжуулалтын, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомж, эрх зүйн актууд, олон улсын гэрээ хэлэлцээр зэрэг ордог.



Зураг 2. Инкубаторын орчин

(инкубаторын амжилттай хэрэгжих орчинг бүрдүүлэх хүчин зүйлс болон түүний харилцан хамаарлыг харуулдаг. Мөн гадаад болон дотоод нөхцөл байдлыг харуулдаг)

Дээрх диаграм нь олон улсын түвшинд инкубаторын цогц орчинг дүрслэн гаргасан.⁶ Бизнес инкубаторын үйл ажиллагааг эрчимжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхэд томоохон байр суурь эзэлдэг хүчин зүйл бол яах аргагүй засгийн газрын идэвхжүүлэлт дэмжлэг юм. Зарим улс орнууд тэдний үйл ажиллагааг дэмжих зорилгоор татварын хөнгөлөлт үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тусгай хөтөлбөрийг боловсруулан төсөл хэрэгжүүлэх зэрэг олон үйл ажиллагааг явуулдаг.

Олон улсад технологи бизнесийн инкубаторын таатай орчинг бүрдүүлэхэд зөв бодлого баримтлах, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх хэд хэдэн үндсэн зарчим байдаг. Үүнд: Засгийн газар болон бусад байгууллагаас авч хэрэгжүүлэх бодлого:

- ✦ Үндэсний ЖДҮ-ийг дэмжих, технологийн хөгжлийг хурдасгах зорилготой бодлогыг боловсруулахдаа өөрийн дотоодын үйлдвэрлэгчид, технологийн үйлдвэрлэл явуулдаг байгууллага, аж ахуй нэгжийн саналыг судалж, тэдэнтэй харилцан уялдаж байх;
- ✦ Шинжлэх ухаан технологийн үндэсний бодлоготой нийцэж байх;
- ✦ ЖДҮ-ийн хөгжлийн бодлогын үндэс болох төрийн зохицуулалтын хэлбэрийг зөв томъёолон, засгийн газрын оролцооны хүрээг тодорхойлох;
- ✦ Санхүүжилтийн хэлбэрийг заавал тусгаж, энэ талын асуудлыг шийдэлд хүргэсэн байх.

Хууль эрх зүйн зохицуулалтыг хийхэд :

- ✦ Инкубаторын тогтвортой, үр ашигтай ажиллах эрх зүйн нөхцөл байдлыг бий болгох;
- ✦ Аж ахуй эрхлэгчдийн эрх зүйн орчинд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог ч ижил тусгаж гаргах;
- ✦ Тэдний үйл ажиллагаанд хөнгөлөлт үзүүлэх заалтуудыг хуулинд тусгаж өгөх, жишээ нь татварын тухай хууль, экспорт, импортын хууль, газрын тухай хууль, хөдөлмөрийн тухай хууль г.м.

Эдгээр нийтлэг зарчмуудыг улс орон бүр өөрийн дотоодын ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих бодлого зохицуулалтыг боловсруулахад тусгаж өгдөг.

Америкийн нэгдсэн улс

АНУ-н засгийн газраас хувийн хэвшлийн салбарт технологийн хөгжлийг дэмжих, инкубацийг хөгжүүлэх чиглэлээр их анхаарах бодлого явуулснаар эдийн засгийн хурдацтай хөгжлийг бий болгож чадсан. Тиймээс ч АНУ-д ажлын байрны 60 хувь, ҮНБ-ний 40 хувь нь ЖДҮ-т оногдож, инновацийн 55 хувь нь энэ хүрээнд хийгдэж байна.⁷ Түүнчлэн АНУ-ийн бизнес инкубаторыг дэмжих бодлого нь маш идэвхитэй үр дүнтэй хэрэгжиж байгаагаас гадна АНУ-д технологи бизнес инкубаторын бодлого зохицуулалтын хамгийн том байгууллага болох ESCWA (Science and Technology Policies in the Twenty-First Century) байрладаг.

АНУ нь ЖДҮ, хувийн аж ахуй эрхлэгчдийг дэмжих, тэдэнд таатай орчинг бүрдүүлэх сүүлийн жилүүдэд баталсан хууль, эрх зүйн актуудаас авч үзвэл:

- Шинжлэх ухаан технологийн талаар засгийн газраас баримтлах бодлого (1993);

⁶ J. Bischoff. Regional perspectives on Promoting Business Technology Incubation system. 2002, Ulaanbaatar

⁷ United States National Business Incubation Association Report 2006.03

- Шинжлэх ухаан, технологи, бизнес үйлдвэрлэлийн нэгдэл /корпораци/-ийн үлгэрчилсэн дүрэм-инкубаторын үйл ажиллагааны онцлог шинж (2002);
- АНУ-н шинжлэх ухаан технологи, технологи бизнесийн инкубаторыг хөгжүүлэх 2015 он хүртэл үндэсний хөтөлбөр (2001);
- ЖДҮ-ийг дэмжих татварын хөнгөлөлтийн дүрэм (1998);
- Бизнесийн байгууллагын хэлбэр, түүний зохицуулалтын хууль-инкубаторын хэлбэр (2002);
- United States National Business Incubation Association (USNBIA), бизнес инкубаторын үйл ажиллагаа, санхүүжилтийн хэлбэр (1999).

Үйлдвэрлэгчид, аж ахуйн нэгжүүдийн санхүү болон технологийн хүчин чадавхийг дэмжихгүйгээр мэдээллийг бий болгож хөгжүүлэгч байгууллагуудыг хөгжүүлэх нь эдийн засагт үр ашиг авчирдаггүй гэдгийг хүлээн зөвшөөрөх болсноор АНУ-ын засгийн газар төрийн эрдэм шинжилгээний болон инкубатор-ын боловсон хүчин, тоног төхөөрөмжинд тулгуурлан инновацийн гол гүйцэтгэгч хүчин болсон хувийн секторт байгаа үйлдвэрлэгчид, аж ахуй нэгжүүдийг дэмжих чиг хандлага давамгайлж байна.

Технологийн парк, технологи бизнесийн инкубаторын нутаг дэвсгэрт үйлчлэх татварын орчин

Шинжлэх ухаан, технологийн парк, технологи бизнесийн инкубаторт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид татварын доор дурьдсан хөнгөлөлт үзүүлэх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэдэг. Үүнд:

- Үйл ажиллагаа явуулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлснээс хойш тодорхой хугацаанд газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх;
- Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийг тодорхой хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас чөлөөлөх;
- Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулан импортолж байгаа түүхий эд, материал сэлбэг, тоног төхөөрөмжийг импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн татвараас чөлөөлөх;
- Тетант хэлбэрийн парк болон инкубаторын үл хөдлөх эд хөрөнгийн болон орлогын албан татвараас чөлөөлөх.

Эдгээр хөнгөлөлтүүдээс харахад АНУ нь шинжлэх ухаан, технологийн парк, технологи бизнесийн инкубаторт үйл ажиллагаа явуулж байгаа төвүүдийг бодлогын болон татварын таатай орчинг бүрдүүлэн тэднийг санхүүгийн дарамт, шахалтаас хамгаалан ажилладагийг харуулж байна.

Бүгд найрамдах Хятад ард улс

БНХАУ-ын засгийн газраас дээр дурьдсан болон бусад хуулиудын хүрээнд жижиг дунд үйлдвэр, бизнесийг хөгжүүлэх чиглэлээр тодорхой бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсний заримаас нь дурьдвал:

- Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр /ЗГ, 2000 /;
- Орон нутгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих дэд хөтөлбөр /ЗГ, 2003/;
- БНХАУ-ын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /ЗГ, 2003/;
- БНХАУ-ын засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох /ЗГ, 2003/;
- Жижиг бизнесийг хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр /ЗГ, 2001/;
- Аж үйлдвэрийг сэргээх, хөгжүүлэх бодлого /ЗГ, 2002/;

- Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр /ЗГ, 2000/;
- БНХАУ-ын бүсчилсэн хөгжлийг дэмжих хөтөлбөр /ЗГ, 2001/;
- Технологи, бизнесийн инкубацийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр /ЗГ, 2001/;
- Иннувацийг дэмжих үндэсний хөтөлбөр /2002/ зэргийг дурьдаж болох юм.

2000 онд БНХАУ-ын засгийн газрын тогтоолоор “Жижиг дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг баталсан. Энэхүү хөтөлбөрт ЖДҮ-ийг хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлага, хэрэгжүүлэх үндсэн зорилтууд, тэргүүлэх ач холбогдол өгөх чиглэл, салбаруудыг дараах байдлаар тодорхойлсон.⁸ Үүнд:

Нийгэм эдийн засгийн шаардлага

1. Байгаа нөөц боломж дээр тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх замаар ажлын байрыг шинээр бий болгох, хүн амын амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх;
2. Хөдөлмөрийн болон түүхий эдийн нөөцийн хуваарилалт, зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг сайжруулах;
3. Эдийн засгийн өсөлтийн боломжийг илрүүлэх, бүс орон нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах нөхцлийг бүрдүүлэх;

Тэргүүлэгч ач холбогдол өгөх чиглэл, салбарууд

1. Бүс, орон нутгийн эрэлт хэрэгцээг хангах, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
2. Дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
3. Эрчим хүч, зам, усан хангамж, харилцаа холбоо, тээвэр, барилгын материал зэрэг ЖДҮ;
4. Байгалийн баялаг, хоёрдогч түүхий эдийг ашиглах чиглэлийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

Түүнчлэн 2003 оны 124-р тогтоолоор засгийн газрын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө зэрэгт ЖДҮ-ийг хөгжүүлэх төрийн бодлогыг тодорхойлон, авч хэрэгжүүлэх цогц арга хэмжээг тусгасан.

Бүгд найрамдах Солонгос улс

Солонгос жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих замаар орон нутгийн хөгжлийг хангах бодлого баримталдаг. “ЖДҮ-ийг дэмжих эрх зүйн акт”, 1997 оноос идэвхтэй хэрэгжиж эхэлсэн ЖДҮ-ийг бизнес инкубаторын тусламжтай хөгжүүлэх “Аж ахуй нэгжийг идэвхжүүлэх онцгой арга зам акт” зэргийг гарган даган мөрдөж байна.⁹

Дараагийн хүснэгтэнд Солонгосын засгийн газраас дотоодын ЖДҮ-ийг дэмжих бодлогын хүрээнд үзүүлж буй дэмжлэгийн хэлбэрийг үзүүлэв.

⁸ Жижиг дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, 2005

⁹ Report 2004, Industrial Development Organization of Korea, 2004/01/22

Хүснэгт 1

Засгийн газрын ЖДҮ-ийг дэмжих бодлого

Дэмжих хөтөлбөр		Агуулга
Байршлын дэмжлэг	Дүүрэг бүрийн аж ахуй эрхлэгчдийг дэмжих	- Аж ахуй эрхлэгчдийн хөгжлийг үндэсний хэмжээнд мөн хөдөө орон нутагт ижил хэмжээтэй идэвхжүүлэх. - Барилгын татвараас чөлөөлөх
	Хаягийн бүртгэлд хамруулах	- Орон нутагт бүртгэн ажлын байр, байршлыг гаргаж өгөх - Инкубатор оршин байгаа газар талбайг бусад зорилгоор ашиглахаас хамгаалах
	Газрын төлбөрийг бууруулах	Бүртгэлийн болон эзэмшлийн татвараас чөлөөлөх (Газрын татвараас 50% чөлөөлөх)
	Технологийн, R&D парк байгуулах	Технологийн парк байгуулах Түүний хүрээнд бизнес инкубаторыг хөгжүүлэх
Санхүүгийн дэмжлэг	Нөөцийн санг төрөлжүүлэх	Гадаад болон дотоодын томоохон компаниудыг ЖДҮ-д хөрөнгө оруулахад түлхэх
	Капиталын хуримтлалыг нэмэгдүүлэх	- Татвараас чөлөөлөх, - Angel капиныг нэмэгдүүлэх
	Капиталын сан байгуулах	
Технологи болон хүчин чадлыг нэмэгдүүлэх дэмжлэг	Технологийн нийлүүлэгч болон хэрэглэгчдийг хооронд нь холбох	Технологи дамжуулах агентлагийг байгуулах

Солонгос улс нь ЖДҮ-ийг дэмжих, бизнес инкубаторын хөгжлийг идэвхжүүлэх зорилгоор төрөөс дэмжих бодлого явуулдаг нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Энэ дэмжлэг туслалцааг зохицуулах хууль эрх зүйн орчинг ч сайн бүрдүүлж өгсөн.

Тусгагдсан байдаг хуулиудын заримыг нь дурьдвал:¹⁰

- ✚ ЖДҮ-ийг дэмжих тухай хууль (1999);
- ✚ БНСУ-ын аж үйлдвэрийн хөгжлийн онцгой хууль (2002);
- ✚ Шинжлэх ухаан, технологийн тухай хууль (2003);
- ✚ Иннувацийн тухай хууль (2000);
- ✚ Онцгой татварын хууль;
- ✚ Муж, орон нутгийн татварын тухай хууль;
- ✚ Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх акт;
- ✚ Судалгаа шинжилгээний хөгжлийн акт бичиг гэх мэт хуулиудаар зохицуулсан байдаг.

Үүнээс онцгойлон татварын хөнгөлөлтийн дэмжлэгийг авч үзвэл:

¹⁰ Report 2004, Industrial Development Organization of Korea, 2004/01/22

Хүснэгт 2

Татварын хөнгөлөлт

Татвар	Хөнгөлөлт	Хууль
Компанийн татвар/ орлогын татвар	✚ Эхний жил татвараа 50% бууруулдаг, эхний жил дууссаны дараа мөн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш дуусах 5 жилийн татварын хөнгөлөлт үзүүлдэг	Онцгой татварын хууль 6-р бүлэгт
Бүртгэлийн татвар	✚ Хэрэв бизнес инкубаторт бойжих бол бүртгэлийн татвараас 100% чөлөөлнө.	Мужийн татварын тухай хууль 280 зүйл
Хөрөнгийн татвар	✚ 50% хөнгөлнө /бизнес инкубаторт бойжиж байгаа бол /	Мужийн татварын тухай хууль 280 зүйл

Засгийн газраас ЖДҮ-ийг болон бизнес инкубаторыг дэмжсэнээр шинээр бизнес эрхэлж байгаа болон ЖДҮ эрхлэгчид нь бизнес инкубаторт хамрагдах, үйлчилгээг авах нь нэмэгдэж ингэж бизнесийн таатай орчинд бойжсоны үр дүнд ЖДҮ-ийн үйл ажиллагаанд гарах эрсдэл нь багасч цаашид зах зээлд гарч амжилттай үйл ажиллагаа явуулж чадахуйц болсон байдаг.

Непал улс

Непал улс нь ЖДҮ-ийг бизнес инкубаторт бойжуулж, өрсөлдөх чадвар бүхий санхүүгийн эх үндэс суурьтай, өндөр технологид тулгуурласан аж ахуйн нэгж болгон бойжуулахад үндсэн чиглэлийг барьдаг. Инкубаторууд нь засгийн газар сектор, хувийн болон төрийн бус сектортай уялдаа холбоотой үйл ажиллагааны цогц байдлаар ажиллах ёстой гэж үздэг. Эдгээр байгууллагуудад:

- Үйлдвэр худалдааны яам;
- Непалын “Rastra” банк;
- Банкуудын холбоо;
- Грантын их сургууль;
- Непалын Худалдаа үйлдвэрлэлийн танхимын холбоод;
- Непалын ЖДҮ-ийг хөгжүүлэх холбоо;
- Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн холбоо зэрэг байгууллагууд ордог.

Засгийн газар нь инкубаторын санхүүжилт хөрөнгө оруулалтанд зориулж “Инкубаторын сан”-г байгуулдаг ба энэ сангийн үйл ажиллагааг өндөр технологид тулгуурласан Бизнес инкубаторын үндэсний комисс нь удирддаг.

Инкубаторын хөгжлийн бодлого зохицуулалтанд голлох үүрэг гүйцэтгэдэг байгууллагуудыг *засгийн газар, төрийн бус байгууллага, хувийн хэвшил* хэмээн гурав хувааж авч үздэг.

1. Төрийн байгууллагууд: Энд ЖДҮ-ийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, шаардлагатай дэмжлэгийг үзүүлдэг.

- ЖДҮ-ийн хэлтэс (DOCSI)
- ЖДҮ-ийн сургалтын төв (CSTIC)
- Хүрээлэн буй орчны удирдлагын институт ордог.

Төрийн байгууллагуудын удирдлагын төв нь Kathmandu-д байрлах бөгөөд бүс нутгийн удирдлагатай харилцан үйл ажиллагаагаа явуулдаг.

2. Төрийн бус сектор: олон улсын төрийн бус байгууллагууд болон хөгжлийн агентлагууд нь инкубаторын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ихэнх

хөгжлийн агентлагууд нь бүс нутгийн хөгжилд чиглэдэг ба тухайн орон нутагт тохирсон бодлогыг боловсруулахыг илүүд үздэг. Үүнд:

- Хувийн секторыг дэмжих төсөл;
- Helvetas, Elam төсөл;
- ЖДҮ-ийг дэмжих төсөл;
- Хувийн секторын хөгжлийн төлөвлөгөө;
- Азийн хөгжлийн сан зэрэг байгууллагууд ордог.

3. Хувийн сектор:

- Үйлдвэр худалдааны холбоо;
- ЖДҮ-ийн хэлтэс (DOCSI)
- Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн холбоо
- Банкуудын холбоо
- Бизнес хөгжлийн төв зэрэг байгууллагууд ордог.

Тэд өөрсдийн бизнесийн санхүүгийн болон үйлдвэрлэлийн таатай орчинг бүрдүүлэх талаар саналаа өгч уялдаа холбоотой ажилладаг. Мөн Непал нь технологи бизнесийн инкубаторт хамрагсдад тодорхой хөнгөлөлтүүдийг үзүүлж, тэднийг төгссөний дараах үеүдэд ч дэмжлэг үзүүлдэг.

Бизнес икубаторын үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомжууд:

- Банк болон санхүүгийн институтын зохицуулалт
- Үйлдвэрлэлийн бодлого
- Гадаадын хөрөнгө оруулалт- нэг цонхны бодлого
- Гадаадын хөрөнгө оруулалт-технологии дамжуулалтын акт
- Үйлдвэрийн компанын акт
- Орлогын татварын хууль зэрэг хууль тогтоомжууд ордог.

Непал улс нь ЖДҮ-ийн таатай орчинг бүрдүүлэхийн тулд нилээд хүчин чармайлт гарган ажиллаж байгаа улс юм.

Эдгээр улсуудын туршлагаас харахад инкубаторын бодлого зохицуулалт нь түүний хөгжлийн таатай орчинг бүрдүүлж, хөгжлийн хурдацыг тодорхойлдог. Хөгжлийн орчны бодлого зохицуулалтын гол байгууллага нь улс орон бүрт өөрийн онцлоготой байдаг хэдий ч судалсан 5 улсын хувьд засгийн газар болон ЖДҮ-ийг дэмжих Шинжлэх ухаан технологийн инкубаторын төвүүд нь үйл ажиллагааны таатай орчинг бүрдүүлэх гол хүч болж байдаг нь харагдаж байна. Мөн засгийн газар болон хэрэгжүүлэгч агентлагуудын харилцан уялдаа холбоотой үйл ажиллагаа нь бизнес инкубаторын хөгжлийн таатай орчинг бүрдүүлж чадна.

Мөн улс орнууд бизнес инкубаторыг хөгжүүлэхдээ харилцан адилгүй зорилго тавьж ажилладаг ба тухайлбал АНУ инкубаторуудын тусламжтайгаар бүс нутгийн хөгжлийн түвшинг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хурдасгах, ажил эрхлэлтийг дэмжих зорилго тавьсан бол Хятад улс нь өндөр технологид суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэх, экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих, БНСУ нь хуучин үеийн томоохон үйлдвэрүүдийн суурин дээр үүссэн олон жижиг үйлдвэрүүдийг дэмжин хөгжүүлэх онцгой технологийг дэвшүүлэн ажиллаж байна.

Төрөөс инкубаторыг дэмжих цогц бодлого боловсруулж хэрэгжүүлдэг. Энэ нь ямар нэгэн салбар, эсвэл ямар нэг байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн дагавар хөтөлбөр бус, харин бие даасан хөгжлийн хөтөлбөр байж чаддаг. Ингэснээр энэ бодлого нь БИ-ддаа хүрч хэрэгжих мөн хэрэгжилтэнд хяналт тавихад ч хялбар байдаг.